Z үеийн оюутнуудын суралцах сонирхол ба оролцооны түвшинг судалсан дүн

О.Отгонцэнд[1], Б.Ганбаатар[2], Б.Одгэрэл[3], Ж.Ариунаа[3], Д.Энхболд[4], С.Дэлгэрмаа[5], Р.Оргилмаа[5], Д.Солонго[5]

[1]АШУҮИС, Сувилахуйн сургууль, Суурь сувилахуйн тэнхим
[2]АШУҮИС, Сувилахуйн сургууль, Анагаахын суурь шинжлэх ухааны тэнхим
[3]АШУҮИС, Сувилахуйн сургууль, Ерөнхий эрдмийн тэнхим
[4]АШУҮИС, Сургалтын бодлого, зохицуулалт, чанарын баталгаажуулалтын газар
[5]АШУҮИС, Сувилахуйн сургууль, Насанд хүрэгсдийн сувилахуйн тэнхим
Цахим шуудан: otgontsend@mnums.edu.mn, Утас: 99286564

Түлхүүр үг:
Z үе
Оюутан
Суралцах сонирхол
Хичээлийн оролцоо

Товч утга:
Үндэслэл: Судлаачдийн тэмдэглэснээр Z үеийн оюутнууд 1995 оноос хойш төрсөн хүмүүс ба онцлог шинж чанар нь нэг зэрэг олон ажил амжуулах чадвартай, уламжлалт суралцах арга барилыг таашаадаггүй, тэвчээр муутай, анхаарал төвлөрөл сул, багаар ажиллахаасаа илүү бие дааж ажиллахыг илүүд чухалчилдаг, уламжлалт суралцах арга барилыг таашаадаггүй, тэвчээр муутай, сэтгэцийн эмгэгт амархан өртдөг шинэ үеийн нэг хэсэг гэж тодорхойлсон байна. **Зорилго:** Сувилахуйн сургуульд суралцаж буй Z үеийн оюутнуудын хичээлд оролцох оролцооны түвшинг судлах. **Арга, аргачлал:** Судалгааг аналитик судалгааны агшингийн загвар, тоон судалгааны асуумжийн аргаар хийж гүйцэтгэсэн. ба 2025 оны 2-р сарын 1-нээс 4-р сарын 1-ний хооронд гүйцэтгэсэн. Судалгаанд АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн сувилахуй, эх барихуй, хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, уламжлалт анагаахын сувилахуйн 420 оюутнуудыг хамруулав. Z үеийн оюутнуудын хичээлд оролцох оролцоог үнэлэхийн тулд Student Course Engagement Questionnaire (Handelsman, 2005)-хувилбарыг ашигласан. Асуумжийн найдвартай байдлыг үнэлэхэд Cronbach's α=0.955 байв. Судалгааг статистик боловсруулалтын SPSS-25.0 программыг ашигласан ба P утга 0.05-аас бага тохиолдолд статистикийн үнэн магадлалтай гэж тооцов. **Үр дүн:** Судалгаанд нийт 420 оюутан оролцсон ба тэдний 91.9% нь эмэгтэй, 8.1% нь эрэгтэй оюутан байв. Мэргэжлээр нь авч үзвэл 57.1% нь сувилахуй, 22.6% нь эх барихуй, 8.8% нь хөдөлгөөн засалч, 11.5% нь бусад мэргэжлийн оюутнууд байв. Оюутнуудын хичээлийн идэвх оролцоо, хувийн хариуцлага ба хичээл зүтгэл, суралцах хандлага ба сонирхол гэсэн бүлгүүдэд хуваан, судалгаанд оролцогчдын нас, суралцаж буй мэргэжил, дамжаа зэрэг үзүүлэлтийн хооронд хамаарлыг Пеарсоны корреляцийн шинжилгээгээр тооцоолоход суралцагчийн идэвх оролцоо нь хувийн хариуцлага хичээл зүтгэлтэй (r=0.828), суралцах хандлага ба сонирхолтой (r=0.825), хувийн хариуцлага, хичээл зүтгэл болон суралцах хандлага, сонирхол хооронд (r=0.903) шууд эерэг хамааралтай (p<0.01) байв. Харин судалгаанд оролцогчдын нас нь суралцаж буй дамжаатай (r=0.381) сул эерэг хамааралтай байсан бол суралцаж буй мэргэжил болон дамжаа хооронд (r=-0.146) сул урвуу хамааралтай (p<0.01) байна. Суралцаж буй дамжаа, суралцах хандлага ба сонирхол хооронд (r=-0.107, p<0.05) сул урвуу хамааралтай байна. **Дүгнэлт:** Судалгаанд хамрагдсан Z үеийн оюутнуудын суралцах сонирхол, хичээлд оролцох байдал нь тэдний хувийн хариуцлага, хичээл зүтгэл, суралцах хандлагатай өндөр хамааралтай (r=0.82–0.90, p<0.01) байна. Оюутнуудын ихэнх нь суралцах хүсэлтэй, хичээлдээ тогтмол оролцдог, уламжлалт арга барилд дургүй, дадлага сургалтад илүү сонирхолтой байна.

Үндэслэл: Судлаачид сүүлийн жилүүдэд дижитал технологихурдацтайхөгжихийнхэрээр1995оноосхойш төрсөн Z үеийн оюутнууд боловсролын тогтолцоонд давамгайлах болсон. Энэ үеийн онцлог шинж чанар нь олон ажил амжуулах чадвартай, уламжлалт суралцах арга барилыг таашаадаггүй, тэвчээр муутай, анхаарал төвлөрөл сул, багаар ажиллахаасаа илүү бие дааж ажиллахыг илүүд чухалчилдаг, уламжлалт суралцах арга барилыг таашаадаггүй, тэвчээр муутай, сэтгэцийн эмгэгт амархан өртдөг шинэ үеийн нэг хэсэг гэж тодорхойлсон байна[1].

Сувилахуйн боловсролын салбарт Z үеийн оюутнууд уламжлалт лекц хэлбэрийн сургалтаас илүү практикт суурилсан, симуляци, хосолсон сургалт, цахим орчны идэвхтэй оролцоог шаарддаг, технологид байнга найдсанаар хүн хоорондын харилцаа багассан байдал нь нийгмийн болон харилцааны ур чадварт сөргөөр нөлөөлж, сэтгэцийн эмгэгт амархан өртдөг, лекц унших дургүй, суралцах үйл явцад өөрсдөө хичээлд идэвхитэй оролцохыг хүсдэг, практик мэдээллээр хангагдах, эсвэл агуулга нь бодит амьдралд хэрхэн хэрэглэгдэхийг мэдэхийг хүсэх нь энэ үеийн оюутнуудын онцлогболохыг дурьджээ[2-4].

Судлаач Svanum S (2006) нар нь Z үеийнхэн хичээлдээ идэвхитэй оролцох нь эрдмийн зэрэг, хамгаалах, голч оноо өндөр байхтай шууд хамааралтай болохыг тогтоосон ба ухаалаг утас эсвэл цахим төхөөрөмжөөр интернет болон эргэн тойрныхоо ертөнцтэй тасралтгүй холбогдож байдаг ба оюутнуудын хичээлд оролцох оролцоог ч мөн адил үнэлэх боломжтой гэжээ[5].

Сувилахуйн сургалтад Z үеийн оюутнуудын суралцах сонирхол, хичээлд оролцох түвшинг Student Course Engagement Questionnaire (SCEQ)-ийн хэмжүүрээр тодорхойлон бодит байдлаар үнэлэх нь хичээлд хандах хандлага, хариуцлага, идэвхи хоорондын хамаарлыг судлах, сургалтын арга зүйг шинэчлэх, багшийн сургалтын арга барилыг сайжруулах, технологид суурилсан хичээл заах орчныг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг тодорхойлсон байна.[6]

Shorey S (2021) нарын судалгаанд Z үеийнхэнд тохирсон визуал, интерактив, практикт тулгуурласан сургалтын хэрэгцээ чухал, сувилахуйн боловсролд симуляци, тохиолдолд суурилсан сургалт, багаар ажиллах, технологийн нэгтгэл хэрэгцээтэй болохыг онцолсон байна.[4]

Судлаач Svanum S (2006) нар Z үеийн сувилахуйн оюутнуудын хичээлийн оролцоо, суралцах хандлагыг харьцуулсан судалгааны үр дүнд: оюутны хичээлд идэвхтэй оролцоо нь дүн, дадлага хичээлийн амжилттай хамгаалалт, гүйцэтгэлтэй эерэг хамааралтай болохыг тодорхойлсон байна.[5]

Сувилахуйн сургуульд суралцаж буй Z үеийн оюутнуудын хичээлд оролцох оролцоог судалсан судалгаа байхгүй байгаа тул бид энэхүү сэдвийг сонгосон болно.

Зорилго: АШУҮИС-ийн Сувилахуйн сургуульд суралцаж буй Z үеийн оюутнуудын суралцах сонирхол болон хичээлд оролцох оролцооны түвшинг судлах.

Арга, аргачлал: Сувилахуйн сургуульд суралцаж буй Z үеийн оюутнуудын хичээлд оролцох оролцоог үнэлэхийн тулд дискриптив судалгааны агшингийн загвар, тоон судалгааны асуумжийн аргыг ашигласан ба судалгааг 2025 оны 2-р сарын 1-нээс 4-р сарын 1-ний хооронд гүйцэтгэсэн. Судалгаанд АШУҮИС-ийн Сувилахуйн сургуульд 2024-2025 оны хичээлийн жилд суралцаж байгаа Сувилахуйн бакалавр I, II, III, IV, дамжаанд суралцаж буй сувилахуй, эх барихуй, хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, уламжлалт анагаахын сувилахуйн оюутнуудыг хамруулав. Түүврийн хэмжээг Японы Токио хотын Aoyama Gakuin Их Сургуулийн эрдэмтэн судлаач Taro Yamane-ны 1973 онд боловсруулсан томъёог ашиглаж, 420 оюутныг хамруулав.

$$n = \frac{N}{1 + Ne^2}$$

N - их олонлог
n - түүвэр олонлог
e - алдааны хязгаар
n = 1269/1+1269*0.05=420

Хамруулах шалгуур:

- Сувилахуйн сургуулийн 1-4-р дамжааны оюутан
- Суралцагч судалгаа хийхийг зөвшөөрсөн оюутан

Хасах шалгуур:

- Судалгааг бүрэн хариулаагүй үед

Z үеийн оюутнуудын хичээлд оролцох оролцоог үнэлэхийн тулд Student Course Engagement Questionnaire (Handelsman, 2005)-ийн 23 асуулт бүхий хувилбарыг ашиглаж, хариултыг 1–5 онооны шатлалтайгаар үнэлсэн. Асуумжийн найдвартай байдлыг үнэлэхэд Cronbach's α=0.955 байв.

Хүснэгт 1. Кронбах альфа коэффициентийн утга

Cronbach's Alpha	N of Items
.955	23

Судалгааны үр дүнг нийгмийн ухааны статистик боловсруулалтын SPSS-25 программын ашигласан. Судалгааны хүн амзүйн мэдээлэл, суралцагсдын хичээлд оролцох оролцоог үнэлэхийн тулд корреляцийн шинжилгээ, олон шатлалт регрессийн арга хэрэглэсэн. P утга 0.05-аас бага тохиолдолд статистикийн үнэн магадлалтай гэж тооцов.

Судалгааны ажлын ёс зүйн асуудал: Судалгаа эхлэхийн өмнө АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 24-25/04-02 хурлаар зөвшөөрөл авч судалгааг эхэлсэн. Судалгаанд оролцогчдоос таниулсан зөвшөөрлийн хуудсанд гарын үсгээр зөвшөөрөл авсны дараа судалгаанд оролцуулсан.

Үр дүн: Бидний судалгаанд нийт 420 оюутан оролцсон ба тэдний 91.9% нь эмэгтэй, 8.1% нь эрэгтэй оюутан, 85.5% нь 17–20 насныхан байв. Суралцаж буй мэргэжлээр нь авч үзвэл 57.1% нь сувилахуй, 22.6% нь эх барихуй, 8.8% нь хөдөлгөөн засалч, 11.5% нь бусад

мэргэжлийн оюутнууд байв. Оюутнуудын 75.7% нь 1-р дамжаа, 12.1% нь 2-р дамжаа, 4.5% нь 3-р дамжаа, 7.6% нь 4-р дамжаанд суралцаж байв. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл

Үзүүлэлт	Тоо (420)	Хувь %
Насны бүлэг		
17-20 нас	359	85.5%
20-25 нас	54	12.9%
26-аас дээш настай	7	1.7%
Хүйс		
Эрэгтэй	34	8.1%
Эмэгтэй	386	91.9%
Суралцаж буй мэргэжил		
Сувилахуй	240	57.1%
Сувилагч /дэд бакалавр/	26	6.2%
УАС /дэд бакалавр/	4	1.0%
Хөдөлмөр засал	18	4.3%
Хөдөлгөөн засал	37	8.8%
Эх бурихуй	95	22.6%
Суралцаж буй дамжаа		
1-р дамжаа	318	75.7%
2-р дамжаа	51	12.1%
3-р дамжаа	19	4.5%
4-р дамжаа	32	7.6%

Судалгаанд хамрагдсан оюутнуудын хичээл дэх идэвх оролцоо, хувийн хариуцлага хичээл зүтгэл, суралцах хандлага ба сонирхлыг бүлэглэн хоорондын хамаарлыг тооцов. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдагсдын хичээлийн идэвх оролцоо, хариуцлага, суралцах сонирхлын хамаарлыг судалсан дүн

Үзүүлэлт	Нас	Суралцаж буй мэргэжил	Суралцаж буй дамжаа	Суралцагчийн идэвхи оролцоо	Хувийн хариуцлага, хичээл зүтгэл	Суралцах хандлага ба сонирхол
Нас	1					
Суралцаж буй мэргэжил	-.042	1				
Суралцаж буй дамжаа	.381**	-.146**	1			
Суралцагчийн идэвхи оролцоо	-.076	.024	-.090	1		
Хувийн хариуцлага, хичээл зүтгэл	-.036	-.016	-.080	.828**	1	
Суралцах хандлага ба сонирхол	-.047	-.003	-.107*	.825**	.903**	1

Тайлбар: ***. Correlation is significant at the 0.01 level (2-tailed). *. Correlation is significant at the 0.05 level (2-tailed).*

Сувилахуйн сургуулийн оюутнуудын хичээлийн идэвх оролцоо, хувийн хариуцлага ба хичээл зүтгэл, суралцах хандлага ба сонирхол гэсэн бүлгүүдэд хуваан, судалгаанд оролцогчдын нас, суралцаж буй мэргэжил, дамжаа зэрэг үзүүлэлтийн хоорондын хамаарлыг Пеарсоны корреляцийн шинжилгээгээр тооцоолов. Суралцагчийн идэвх оролцоо нь хувийн хариуцлага хичээл зүтгэлтэй (r=0.828), суралцах хандлага ба сонирхолтой (r=0.825), хувийн хариуцлага, хичээл зүтгэл болон суралцах хандлага, сонирхол хооронд (r=0.903) шууд, эерэг хамааралтай (p<0.01) байна.

Харин судалгаанд оролцогчдын нас нь суралцаж буй дамжаатай (r=0.381) сул эерэг хамааралтай байсан бол суралцаж буй мэргэжил болон дамжаа хооронд (r=-0.146) сул урвуу хамааралтай (p<0.01) байна. Суралцаж буй дамжаа, суралцах хандлага ба сонирхол хооронд (r=-0.107, p<0.05) сул урвуу хамааралтай байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан оюутнуудын идэвх, оролцоог тодорхойлсон дүн

Үзүүлэлт	Тоо	Хувь
Өдөр бүр хичээлдээ ирдэг	277	65.9%
Хичээлийн тэмдэглэлээ сайн хөтөлдөг	250	59.5%
Суралцахыг үнэхээр хүсдэг	242	57.6%
Хичээлээ анхааралтай сонсдог	242	57.6%
Цуг сурч буй оюутнууддаа тусалдаг	241	57.4%
Хичээлдээ сайн суралцаж чадна гэдэгтээ итгэлтэй байдаг	235	55.9%
Тогтмол суурьтай (чанартай) суралцдаг	231	55.0%
Хичээлдээ сайн суралцаж хүчин чармайлт гаргасаар байдаг	230	54.8%

Судалгаанд хамрагдсан оюутны идэвх оролцоог судалж үзэхэд: 65.9% нь өдөр бүр хичээлдээ ирдэг, 59.5% нь хичээлийн тэмдэглэлээ сайн хөтөлдөг, 57.6% нь суралцахыг үнэхээр хүсдэг, 57.6% нь хичээлээ анхааралтай сонсдог 57.4% нь цуг сурч буй оюутнууддаа тусалдаг, 55.9% нь хичээлдээ сайн суралцана гэдэгтээ итгэлтэй байдаг, 55% нь тогтмол суурьтай сайн суралцдаг, 54.8% нь хичээлдээ сайн суралцаж хүчин чармайлт гаргасаар байдаг гэж хариулжээ.

Хэлцэмж: Сүүлийн жилүүдэд дээд боловсролын орчинд технологийн хэрэглээ, цахим сургалтын хурдацтай хөгжиж, Z үеийн оюутнуудын суралцах байдал, хичээлд оролцох оролцоо чухал байр суурийг эзэлж байна.

Судлаач Culp-Roche (2020) нарын судалгаанд багш, оюутны технологийн хэрэглээ, орчны тав тух, хандлага, үе хоорондын ялгааг судалсан ба судалгааны үр дүнд: Generation Y ба Z үеийнхэн технологи ашиглахад илүү итгэлтэй, эерэг сонирхолтой байгааг онцолсон бол судлаач Baby Boomer нар X үеийнхэн суралцах байдалдаа илүү болгоомжтой ханддаг болох нь тогтоосон байна.[10] Харин бидний судалгаанд судалгаанд хамрагдсан сувилахуйн сургуулийн оюутнуудын хичээлийн идэвх оролцоо, хувийн хариуцлага ба хичээл зүтгэл, суралцах хандлага ба сонирхол нь дамжаанаас хамаарч байгаа нь дээрх судалгааны үр дүнтэй ойролцоо байна.

Судлаач Hampton D (2020) нарын судалгаанд Z үеийнхэн цахим орчинд илүү идэвхтэй суралцаж, интерактив арга барилыг илүүд үздэг, уламжлалт лекцийн хэлбэр тэдний анхаарлыг татахгүй байна.[2] Үүнтэй холбогдуулан Gen Z оюутнуудын суралцах сонирхол ба оролцоог судлах нь боловсролын чанарыг сайжруулах, багшийн заах арга барилыг шинэ үеийн хэрэгцээнд нийцүүлэх онолын болон практик ач холбогдолтой болохыг онцолсон байна. Манай орны хувьд сургалтанд академик уламжлалт сургалтыг голчлон орж, лекц, дадлага, семинар хэлбэрээр явуулдаг ба манай судалгаанд хамрагдсан оюутны идэвх оролцоог судлахад: 65.9% нь өдөр бүр хичээлдээ ирдэг, 57.6% нь хичээлээ анхааралтай сонсдог 55.9% нь хичээлдээ сайн суралцана гэдэгтээ итгэлтэй байдаг 54.8% нь хичээлдээ сайн суралцаж хүчин чармайлт гаргасаар байдаг гэж хариулсан байдлаас дүгнэхэд нийт оюутны 35-45 орчим хувь нь уламжлалт сургалтыг таашааддаггүй болохыг харуулсан нь дээрх судалгааны үр дүнтэй дүйцэж байна.

Иймээс Z үеийн оюутнуудын суралцах сонирхол, хичээлд оролцох түвшинг судлахдаа технологийн хэрэглээний тав тух, дижитал орчинд хандлага, суралцах хэв маягийн ялгаа зэрэг хүчин зүйлсийг онцгойлон авч үзэх шаардлагатай байна. Орчин үед сувилахуйн болон анагаахын чиглэлээр суралцаж буй оюутнуудад явуулдаг сургалтын бодлого, сургалтын арга, орчныг шинэчлэх нь тулгамдсан асуудал болж байна.

Дүгнэлт: Z үеийн оюутнуудын суралцах сонирхол, хичээлд оролцох байдал нь тэдний хувийн хариуцлага, хичээл зүтгэл, суралцах хандлагатай өндөр хамааралтай ($r=0.82–0.90$, $p<0.01$) байна. Оюутнуудын ихэнх нь суралцах хүсэлтэй, хичээлдээ тогтмол оролцдог, уламжлалт арга барилд дургүй, дадлага сургалтад илүү сонирхолтой байна.

Ном зүй:

1. *Indriyanti PA, Wijaya D, Muhammad Nur KR. Professionalism values of Generation Z nursing students. Nurs Health Sci J. 2025;5(1).*
2. *Hampton D, Welsh D, Wiggins AT. Learning preferences and engagement level of Generation Z nursing students. Nurse Educator. 2020;45(3):160-164.*
3. *Chicca J, Shellenbarger T. Generation Z: Approaches and teaching–learning practices for nursing professional development practitioners. J Nurses Prof Dev. 2018;34(5):250-256.*
4. *Shorey S, Chan V, Rajendran P, Ang E. Learning styles, preferences and needs of Generation Z healthcare students: A scoping review. Nurse Educ Pract. 2021;57:103247. doi:10.1016/j.nepr.2021.103247*
5. *Svanum S, Bigatti S. Academic course engagement during one semester forecasts college success. J Coll Stud Dev. 2006;47(5):560-568.*
6. *Wang R, et al. Systematic literature review on the effects of blended learning in nursing education. Adv Health Sci Educ. 2024;29(2):1-15.*
7. *Dodson TM. A scoping review of Generation Z nursing students. J Nurs Educ Pract. 2024;14(2):45-52.*
8. *Handelsman MM, Briggs WL, Sullivan N, Towler A. A measure of college student course engagement. J Educ Res. 2005;98(3):184-191.*
9. *Korkut S, Ulker T. Students' learning by producing educational audio-visual resources in skills education: A mixed study. Int J Caring Sci. 2024;17(3):1636-1648.*
10. *Culp-Roche A, Hampton D, Hensley A, Wilson J, Thaxton-Wiggins A, Otts JA, Fruh S, Moser DK. Generational differences in faculty and student comfort with technology use. SAGE Open Nurs. 2020;6:1-6. doi:10.1177/2377960820941394*
11. *Liu Y, Sun X, Zhang P, Han P, Shao H, Duan X, Jiang J. Generation Z nursing students' online learning experiences during COVID-19 epidemic: A qualitative study. Nurse Educ Today. 2021;104:104983.*
12. *Kassam SM, Subramanian S. Enhancing clinical nursing education for Gen Z students through brain-based learning. J Nurs Educ Pract. 2024;14(3):15-22.*
13. *Sumiya S, Kale SN, Singh RA, Nair AS, Abraham SE, Thomas J, Kanika, Begum F. Understanding Generation Z in nursing education: A review of learning styles, challenges, and opportunities. J Carcinog. 2025;24(1):1477-3163.*

A Study on the Learning Motivation and Engagement Level of Generation Z Students

Otgontsend O[1], Ganbaatar B[2], Odgerel B[3], Ariunaa J[3], Enkhbold D[4], Delgermaa S[5], Orgilmaa R[5], Solongo D[5]

[1]Department of Fundamental nursing, School of Nursing, MNUMS
[2]Department of Basic medical science, School of Nursing, MNUMS
[3]Department of Basic sciences, School of Nursing, MNUMS
[4]Division of Educational policy, management and quality assurance, MNUMS
[5]Department of Adult nursing, School of Nursing, MNUMS
E-mail: otgontsend@mnums.edu.mn, Tel: +976-99286564

Abstract:
Background: Generation Z students, born after 1995, are characterized by their ability to multitask, low tolerance for traditional learning methods, impatience, short attention span, and preference for working independently rather than collaboratively. They are also considered more vulnerable to mental health challenges compared to previous generations.
Aim: To assess the level of academic engagement among Generation Z students studying in the School of Nursing.
Materials and Methods: This descriptive, cross-sectional quantitative study was conducted from February 1 to April 1, 2025. A total of 420 students majoring in nursing, midwifery, physical therapy, occupational therapy, and traditional medicine nursing at the School of Nursing, Mongolian National University of Medical Sciences, participated in the study. The *Student Course Engagement Questionnaire* (Handelsman, 2005) was used to evaluate students' engagement levels. The reliability of the questionnaire was confirmed with a Cronbach's α of 0.955. Statistical analysis was performed using SPSS version 25, and results were considered statistically significant at $p<0.05$.
Results: Among the 420 participants, 91.9% were female and 8.1% were male. By major, 57.1% studied nursing, 22.6% midwifery, 8.8% physical therapy, and the remainder were from other disciplines. Student engagement was analyzed across three domains: academic involvement, personal responsibility and effort, and learning attitude and motivation. Pearson correlation analysis revealed strong positive correlations between academic involvement and personal responsibility/effort ($r=0.828$), learning attitude and motivation ($r=0.825$), and between responsibility/effort and learning attitude/motivation ($r=0.903$) ($p<0.01$). Age showed a weak positive correlation with year of study ($r=0.381$), while major and year of study had a weak negative correlation ($r= -0.146$) ($p<0.01$). Year of study and learning motivation also showed a weak negative correlation ($r=-0.107$, $p<0.05$).
Conclusion: The learning motivation and class engagement of Generation Z nursing students were found to be strongly correlated with their sense of responsibility, effort, and learning attitude ($r=0.82–0.90$, $p<0.01$). Most students demonstrated consistent participation and motivation to learn, showed less interest in traditional teaching approaches, and preferred practical training.

Keywords: Generation Z, students, Learning motivation, Class engagement